

2

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ БА ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Д. Бадарч

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих асуудал төр засгийн бодлогын төвд байх боллоо. Үйлдвэрлэлийн хөгжлийн асуудлыг ярихаас өмнө түүний өнөөгийн байдалд бодит дүгнэлт хийх хэрэгтэй байна.

Эдийн засгийн өсөлт хамгийн өндөр байсан 1989 онд дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд аж үйлдвэр 37.2 хувь, худалдаа хангамж 19 хувь байсан бол 1998 оны байдлаар аж үйлдвэр 24.1, худалдаа хангамж 18.9 хувийг тус тус эзлэх болжээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өсөлт нь 3.5 хувь байсан 1998 онд аж үйлдвэрийн салбарын өсөлт 3.3 хувь байлаа. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 70 орчин хувийг цахилгаан дулааны үйлдвэрлэл, геологи, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангаж байлаа. 1995 онд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр дотоодын нийт бүтээгдэхүүний 12 хувийг эзэлж байсан бол 1999 онд 7.6 хувийг эзлэх болжээ. Дээр дурьдсан тоо баримтаас Монгол улсад үйлдвэргүйжилт "deindustrialization"-ийн процесс явагдаж байна гэсэн дүгнэлтийг хийж болох байна. Эндээс харахад дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөнд аж үйлдвэрлэлийн бусад салбар түүний дотор малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэлийг өсгөх шаардага тавигдаж байна.

Боловсруулах үйлдвэрийн уналтад цахилгаан дулааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой зардлын өсөлт, материал түүхий эд бэлтгэлийн эргэлтийн хөрөнгө дутсан, бүтээгдэхүүн борлуулах дотоод, гадаад зах зээлийн өөрчлөлт менежментийн хоцрогдол зэрэг хүчин зүйл нөлөөлсөн юм. 2000 оны урьдчилсан дүнгээр ДНБ-ний өсөлт 3.0 хувь байхад аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлт өнгөрсөн онтой харьцуулахад 0.2 хувиар өсөх дүнтэй байна.

Энэ нь эдийн засгийн өсөлтийг жилийн 6 хувь болгох Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын үед бүр хурцаар тавигдаад байна. Энэхүү

өсөлтийг хангах нэг эх сурвалж нь экспортын чиглэлтэй үйлдвэрүүдэд туслалцаа үзүүлэх явдал юм. Үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг туслалцаа гэдгийг шууд утгаар нь ойлгож болохгүй. Учир нь энэ бүрэн багц асуудлын хүрээнд шийдэгдэнэ. Энэхүү асуудлыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэл бүрээр авч үзвэл.

А. Ноолуурын үйлдвэрлэлийн хувьд

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалт орсон байгаа. Өнгөрсөн 10 жилийн дотор ноолуурын хэрэгцээний өсөлттэй холбоотойгоор ямааны тоо толгой 4-өөс 11 сая болон өсч түүхий ноолуурын жилийн үйлдвэрлэл 3450 тоннд хүрлээ. Үүнтэй холбоотойгоор жилд ноолуур боловсруулах салбарын бүтцэд нилээд өөрчлөлт гарсан бөгөөд 1989 онд ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах нэг үйлдвэр байсан бол өнөөдөр ноолуур боловсруулдаг том, жижиг үйлдвэрийн тоо 53 болжээ.

Салбарын бүтцийн өөрчлөлттэй уялдан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төрөл, хэмжээнд ч өөрчлөлт гарлаа. Самнасан ноолуурын үйлдвэрлэл 1999 онд 1989 оныхоос 53.6 хувиар өссөн байхад сүлжмэлийн үйлдвэрлэл дөнгөж 29.6%-иар өссөн байна.

Үйлдвэрлэлийн тоо нэмэгдэхийн хамт ноолуурын анхан шатны боловсруулалтын хүч чадал, түүхий эдийн нөөцийн хоорондын зохистой харьцаа алдагдаж, улмаар суурилагдсан хүч чадлыг бүрэн ашиглахгүй байх, дотоодын үйлдвэрүүд түүхий эдээр дутагдах зэрэг сөрөг үр дагаварууд бий болсон юм. 1999 оны байдлаар ноолуурын анхан шатны боловсруулалт, үүний дотор угаах хүч чадал 1989 оныхоос 55.0, самнах 60 хувиар өсөж, энэ нь түүхий эдийн нөөцөөс 40 хувиар даваад байна. Иймээс угаах самнах үйлдвэрлэлийн хүч чадлын ашиглалт дөнгөж 67 хувьтай байна. Харин өнгөрсөн 10 жилд сүлжих хүч чадал бараг нэмэгдээгүй байгаа нь түүхий эдийг их хэмжээгээр экспортлох болсонтой холбоотой.

Үйлдвэрлэлийн тоо хэт өсөх нэг шалтгаан бол гадаадын хөрөнгө оруулалттай ноолуур боловсруулах үйлдвэрийг байгуулагдсан өдрөөс эхлэн 3 жил аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвараас 100, дараагийн 3 жилд 50 хувиар чөлөөлөх хөнгөлөлтийн нөхцөл олгосон явдал юм. Нэгэнт хүч чадал ханасан өнөө үед энэхүү хөнгөлөлтийг эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүдэд түлхүү олгож, тухайн шатны үйлдвэрүүдийг татварт хамруулах замаар зарим зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Засгийн газраас 1996 онд ноолуурын экспортын хorigийг цуцалсан. Гэхдээ экспортыг багасгах, дотоодын үйлдвэрүүдийг түүхий эдээр тасралтгүй хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 1997 оноос нэг килограмм ноолуурт 4000 төгрөгийн экспортын татвар тогтоосон боловч экспорт буурахгүй өссөн хэвээр, тухайлбал 1999 онд 769.3, 2000 оны эхний 8 сарын дүнгээр 671.5 тонн ноолуур экспортлосон мэдээтэй байна. 2000 оны 4 дүгээр сарын 15-наас ноолуурыг гүнийн гаалийн

хяналтын дор экспортлож, үүнтэй уялдуулан Өмнөговь аймгийн төвд шинээр гүнийн гаалийн хэсгийг байгуулан ажиллаж байгаа боловч экспортын зохицуулалтанд дорвитой үр дүн гарсангүй.

Түүхий эдийг экспортлох болсноор Монгол улс жил тутам 2.8-8.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох боломжоо алдаж байна гэсэн тооцоо гарч байна. Иймд ноолуур боловсруулах салбарт үүссэн хүндрэлийг арилгах, экспортыг нэмэгдүүлэхийн тулд:

1. Анхан шатны боловсруулалтын үйлдвэрийн тоо, түүхий эдийн нөөцийн зохистой харьцааг бий болгох. Ноолуурын анхан шатны боловсруулалтын үйлдвэрлэл эрхлэгчдийг аттестатчилалд хамааруулан зөвхөн түүхий эд бэлтгэн нийлүүлэх экспортлох чиглэлээр ажиллаж буй ба ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоох

2. Ээрэх, сүлжих хүч чадлыг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

3. Түүхий эдийн нөөц бүрдүүлэх сан байгуулж, дотоодын үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх замаар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж тэдний жигд ажиллагааг хангах шаардлага гарч байна.

4. Эх орны ноолуурын чанарыг дэлхийн зах зээлд суртачлах, ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх асуудал маш чухлаар тавигдаж байна. Энэ асуудлын хүрээнд ноолуурын чанарын шинжилгээний лаборатори байгуулж бүтээгдэхүүний чанарын хөндлөнгийн хяналт бий болгосноор монголын ноолуур барааны тэмдэгтэй болох юм.

5. Гаалийн хяналт, шалгалтыг сайжруулах хэрэгтэй байгаа юм. Жил тутам 500 орчим тонн түүхий ноолуур балансаас дутаж байна. Үүнийг конторбанд гэж ойлгож болно. Энэ асуудлыг шийдэх асуудлын хүрээнд салбарын мэргэжлийн холбоотой гэрээний үндсэн дээр хамтран ажиллах, гаалийн байгууллагын ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих замаар олон нийтийн зүгээс тавих хяналт, шалгалтыг сайжруулах зэрэг болно.

Б. Ноосны үйлдвэрлэлийн хувьд

Ноосны жилийн үйлдвэрлэлийн хэмжээ дунджаар 16 мянган тонн байна. Хэрэв 1989 онд ноос боловсруулах 13 үйлдвэрт жилдээ 15 мянган тонн хонины ноос боловсруулж, 10 мянган тонн угаасан ноос, 5 мянган тонн ээрмэл утас, 2 сая квадрат метр хивс, 1.3 сая ширхэг сүлжмэл, 650 мянган метр эсгий, 600 орчим мянган хос эсгий гутал үйлдвэрлэж, 2 сая квадрат метр хивс экспортолж байсан бол 1999 он гэхэд угаасан ноосны үйлдвэрлэл 84.3, эсгий гутлын үйлдвэрлэл 37.9 хувиар буурч, ноосон даавуу, хөнжил, сүлжмэлийн үйлдвэрлэл зогсоод байна. Энэ нь:

1-рт ноос бэлтгэлийн төвлөрсөн систем задарч, түүний удирдлага салбарын менежментийн мэдлэггүй хүмүүст шилжсэнтэй холбоотой.

2-рт хувьчлалыг хийхдээ технологийн дамжлагаар өөр хоорондоо холбоотой үйлдвэрийг салган тусгаарлаж, жижиг бие даасан компаниуд болгосонтой холбоотой.

3-рт бүтээгдэхүүн борлуулах зах зээл хумигдсан. 1990 оноос өмнө Монгол улсын ноосон бүтээгдэхүүний 90 гаруй хувийг ОХУ-д экспортолдог байсан. 1996 онд ОХУ-аас ноосон нэхмэл, сүлжмэлд 40, хивсэнд 60, БНХАУ-аас ноосон нэхмэл, сүлжмэл, хивсэнд 80 хувийн импортын гаалийн татвар тогтоосон нь дотоодын үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүнээ экспортлох боломжгүй болгосон юм. Хөрш зэргэлдээ орнуудаас манай улсын экспортод сөргөөр нөлөөлсөн импортын татварыг бууруулах талаар гэрээ, хэлэлцээр хийх тодорхой арга хэмжээг Засгийн газраас авч чадаагүй нь ноос боловсруулах салбарын уналт даймжрах нэг гол шалтгаан болж байлаа.

Хэдийгээр ноосон бүтээгдэхүүнийг Европ, Азийн бусад орнуудын зах зээлд борлуулах боломж байгаа боловч бүтээгдэхүүний чанар олон улсын стандартын баталгаагүй нь түүнийг хязгаарлаж байна. Үүний тулд Монгол ноосны өрсөлдөх чадварыг хангах ажлын хүрээнд

1. Монгол хонины ноосны чанарын ангилал тогтоох асуудал хурцаар тавигдаад байна. Үүнээс гадна уг салбарын үйлдвэрлэлийг сэргээхийн тулд
2. Түүхий эдийн экспортыг багасгах арга хэмжээ авах, улмаар экспортын татвартай болгох
3. "Хүн амын орлогын албан татварын тухай хууль"-ийн дагуу суутгадаг дундын суутгалаас угаасан ноосыг чөлөөлж, экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
4. "Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөө, орон нутагт ноос бэлтгэлийн цэгүүдийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын сонирхолд тулгуурлан бий болгох ажлыг зохион байгуулах
5. Түүхий эд бэлтгэлийн стандартыг хэрэглээнд ойртуулан шинэчлэн боловсруулж мөрдүүлэх
6. Импортын ижил төрлийн барааны татварыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрүүдийн зах зээлийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх
7. ОХУ-ын урсгал өрөнд хивс нийлүүлэх талаар холбогдох гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг судлан хэрэгжүүлэхэд анхаарах
8. ОХУ, БНХАУ-аас ноосон бүтээгдэхүүнд тавьсан импортын татварыг бууруулах талаар хоёр талд санал тавьж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

Түүхий ноосны экспортыг багасгах хоёр арга зам байна гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, түүхий ноосны экспортод 15 хувийн татвар тогтоох

Хоёрдугаарт, угаасан ноосны экспортыг нэмэгдүүлэх. Татвар тогтоосноор ноос үнэ, малчдын орлогод ноолууртай адил эрс ялгаатай өөрчлөлт гарахгүй, харин ч ноосны ашиглалтын төвшин сайжирна.

1999 оны байдлаар "Монноос" ХК 1300 тонн угаасан ноос Англид экспортлосон. Тус компани 2001-2004 онд угаасан ноосны экспортыг өнөөгийнхөөс 30 гаруй хувиар өсгөхөөр гэрээ байгуулсан байгаа. Экспортын хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй нэг зүйл бол "Хүн амын орлогын албан татварын тухай хууль"-ийг хэрэгжүүлэх

зорилгоор гаргасан УТЕГ-ын даргын 2000 оны 48 дугаар тушаал. Тушаалд заасан ноос гэж заасан нэр томъёонд түүхий ба угаасан ноос гэсэн нэр томъёог салгаж өгөх, татварыг урьдчилан авдгийг экспортын бараанд төлбөр хийсний дараа авахаар журамлах нь зүйтэй юм. Энэ асуудал боловсруулсан арьсанд мөн хамаарах болно.

В. Арьс ширний үйлдвэрлэлийн хувьд

Монгол улс жилдээ 5.0 сая бог, 600 мянга орчим бод мал нядалж дотоодын хэрэгцээг хангадаг. Арьс шир боловсруулах салбарын хувьд өнгөрсөн 10 жил нь уналтын жилүүд байлаа. 1989 онд арьс боловсруулах үйлдвэр нь жилдээ 5 сая ширхэг арьс боловсруулж, 1150 мянган квадрат метр шервет, 410 мянган квадрат метр шевро, 1000 тонн улны шир, 40 гаруй мянган квадрат савхин дээл, 200 гаруй мянган ширхэг савхин цамц, пиджак, 4 сая хос савхин гутал, 180 мянган ширхэг нэхий дээл үйлдвэрлэж байсан бол 1999 он гэхэд шевретийн үйлдвэрлэл 97.7, шевроны үйлдвэрлэл 99.1, нэхий дээл, савхин гутлын үйлдвэрлэл 99.8 хувиар буурч, улны шир, савхин дээл, цамц, пиджакны үйлдвэрлэл бүрэн зогссон байна. Өнгөрсөн хугацаанд түүхий эдийн экспорт 69.5-83.8 хувиар өсөж, боловсруулсан арьсны экспорт зогссон байна.

Салбарын хэмжээнд анхан шатны боловсруулалтын 3 том үйлдвэр байгаа бөгөөд эдгээр нь 1999 оны байдлаар хүч чадлын 10 хүрэхгүй хувийг ашиглаж байна. Дархан, Улаанбаатар хотын нэхий боловсруулах 2 үйлдвэр, гутал, савхин эдлэлийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаа үндсэндээ зогссон. Харин Дарханы нэхий эдлэлийн үйлдвэр энэ оны 9 дүгээр сараас үйл ажиллагаагаа сэргээж байна. Арьс боловсруулах 70 гаруй үйлдвэр хот, хөдөө орон нутагт бий болжээ. Хэдийгээр эдгээр үйлдвэрүүд нь түүхий эддээ ойр боловч химийн боловсруулалтыг дэд бүтэц хөгжөөгүй газар явуулахад нилээд хүндрэл учирч, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нь нэмэгдсэн тул тэд тогтвортой ажиллаж чадахгүй байна.

Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг сэргээж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд дараах арга хэмжээг авах шаардлага байна. Үүнд:

1. Арьс ширэн түүхий эдэд экспортын татвар тогтоож, дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарах
2. Техник, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн болон өөрсдийн хөрөнгөөр шинэчлэлт хийж, үйлдвэрлэл явуулахад бэлэн болгосон компаниудад эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр бий болгоход нь дэмжлэг үзүүлэх
3. Үйлдвэрийн менежментийг сайжруулахад анхаарч, зах зээлийг өргөжүүлэх, том жижиг үйлдвэрүүдийн уялдаа холбоог сайжруулж, нэг нь нөгөөгөө түүхий эд болон туслах материалаар хангаж байх нөхцлийг бүрдүүлдэг.
4. Импортын ижил төрлийн барааны татварыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээ авах

Гэвч 5 дахь буюу хамгийн гол арга хэмжээ нь түүхий эд үйлдвэрлэгч, бэлтгэгчдийг арьс ширний анхан шатны тордолтод сургах явдал юм. Ингэснээр эцсийн бүтээгдэхүүний гарц өсч чанар сайжрах болно. Цаашид үндэсний үйлдвэрийг дэмжих асуудлын хүрээнд

1-рт Үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгө бий болгох, техник технологийн өөрчлөлт хийх асуудлаар тодорхой төсөл хэрэгжүүлэх

2-рт Үйлдвэрлэлийн менежментийг сайжруулах асуудлын хүрээнд орчин үеийн менежментийн ололттой танилцах, туршлагыг нь судлан нэвтрүүлэхэд хамтран ажиллах саналуудыг дэвшүүлж байна.

Г. Металл боловсруулах болон төмөрлөгийн үйлдвэрлэлийн хувьд

Манай улсын металл боловсруулах салбарын өнөөгийн байдал туйлын хүнд байна. Томоохон үйлдвэрүүдийн механик цех, авто засварын завод (хуучин нэрээр)-ын дэргэд байсан хөнгөн цагаан хайлуулдаг үйлдвэрүүдийг эс тооцвол металл боловсруулах үйлдвэрүүд зогсож байна гэж хэлж болно. 1994 оны 7 сард Японы зээл, тусламжаар байгуулагдсан Дархан-Уул аймаг дахь хар төмөрлөгийн үйлдвэр хүчин чадлынхаа 10 хувийг ашиглаж жилд 145.3 мянган тонн төмөр хайлж, 2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Гэтэл өнгөрсөн хугацаанд хаягдал төмрийг экспортод чөлөөтэй гаргаж, гадаадын хөрөнгө оруулалттай 10 гаруй жижиг үйлдвэр шинээр байгуулагдан, хаягдал төмрийг хайлж, хэлбэржүүлэх, бэлнээр шууд экспортлох эмх цэгцгүй байдал бий болгосон нь үйлдвэрлэлийг түүхий эдгүй болгож дээрх байдалд хүргэжээ.

Хаягдал төмрийн экспорт нэмэгдэж, 1997-1999 онуудад нийт дүнгээр 172.4 мянган тонн төмөр экспортод гарсан байна. Өөрөөр хэлбэл одоогийн байдлаар Монгол улс 6 хүрэхгүй мянган тонн хаягдал төмрийн нөөцтэй болжээ. 1997 онд хаягдал төмөрт экспортын татвар тогтоосон боловч гадаадын хөрөнгө оруулалттай жижиг үйлдвэрүүд нь төмрийг зөвхөн хайлуулж, цувьж, боловсруулсан нэр зүүн татвараас зайлсхийж, экспорт зогсохгүй байна.

Цаашид төмөрлөгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн болгохын тулд

1. Хаягдал төмрийн экспортыг багасгах, боловсруулалтын стандартын шаардлага хангахгүй байгаа жижиг үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зогсоох
2. Төмөрлөгийн үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх дэс дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх
3. Төмөрлөгийн үйлдвэрийг барьж байгуулахад хөрөнгө оруулалтад зарцуулсан зээлийг үйлдвэрийн дүрмийн санд бүртгэж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх таатай орчин бүрдүүлэх.
4. Ижил төрлийн импортын барааны татварыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлийг хамгаалах хэрэгтэй боллоо.

Ийнхүү салбар тус бүрийн хүрээнд дээр дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр үйлдвэрлэл сэргэх боломж бүрдэх болно гэж үзэж байна.